



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/016/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Алтай хот	Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
2026 он	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Цэрэнханд
	Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn
	Аудитор: Э.Сүнжидмаа
	Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есенбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.03.05 № 147

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Алтай сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Алтай сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

Засаг дарга нөөц хөрөнгө арга хэмжээний зардлаас дэмжлэг, хүндэтгэл, ахмадын баяр, тэмцээн уралдаанд 6.9 сая төгрөгийн зарцуулсан.

Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 47.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн

822511000435

16.5.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-д заасныг тус тус зөрчсөн нь санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Говь-Алтай аймгийн Алтай сумыг БНХАУ-ын Хами аймгийн цахилгаан эрчим хүчний шугам сүлжээтэй холбож тус сум цахилгаан эрчим хүчний байнгын эх үүсвэртэй болсон байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд сумын нийт төсөв 3,461.7 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 2,431.7 сая төгрөгийг зарцуулж, 70.2 хувийн биелэлттэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 155 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 84.3 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12 -р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,556,434.3	3,022,938.0
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,268,355.5	1,358,894.4
3	АВЛАГА	301,411.9	245,547.0
4	БАРАА МАТЕРИАЛ	421,002.5	433,820.6
5	НӨӨЦИЙН БАРАА	15,847.0	-
6	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	549,817.5	984,676.0
7	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,332,986.1	2,456,553.3
8	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,332,986.1	2,456,553.3
9	2.2.02	2,233,224.1	2,356,791.3
10	2.2.03	99,762.0	99,762.0
11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	4,889,420.5	5,479,491.3
12	НИЙТ ӨР ТӨЛБӨР	45,502.0	100,948.3
13	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	45,502.0	100,948.3
14	1.1.03	45,502.0	100,948.3
15	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,843,918.5	5,378,543.0
16	Засгийн газрын хувь оролцоо	4,843,918.5	5,378,543.0
17	Засгийн газрын оруулсан капитал	305,025.6	305,025.6
18	дүн	4,536,785.8	5,071,410.3
19	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,107.1	2,107.1
20	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	4,889,420.5	5,479,491.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,027,879.7	2,792,286.1
2	ТАТВАРЫН ОРЛОГО	1,153,460.1	1,329,257.5
3	Орлогын албан татвар	1,092,145.4	1,220,713.6
4	Хувь хүний орлогын албан татвар	1,112,417.7	1,240,475.4
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(20,272.3)	(19,761.8)
6	Хөрөнгийн албан татвар	41,026.0	40,360.3
7	Бусад татвар, төлбөр, хураамж	20,288.7	68,183.5
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	620,770.9	1,463,028.7
9	Тусламжийн орлого	-	217,544.2
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,253,648.7	-
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,607,329.1	1,863,803.5
12	УРСГАЛ ЗАРДАЛ	1,607,329.1	1,863,803.5
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,529,468.5	1,822,842.4

14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	700,162.3	772,079.3
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,701.9	95,221.1
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	256,075.2	292,705.1
17	Хангамж, бараа материалын зардал	62,300.1	59,390.3
18	Нормативд зардал	1,595.0	102.0
19	Эд хогшил, урсгал засварын зардал	57,438.7	137,034.4
20	Томилолт, зочны зардал	24,440.0	22,806.0
21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,998.4	5,037.9
22	Бараа үйлчилгээний бусад зардал	289,756.8	438,466.4
23	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,860.6	40,961.0
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,420,550.6	928,482.7
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	655,208.1	393,858.2
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(655,208.1)	(393,858.2)
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	765,342.5	534,624.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	3,881,792.4	3,881,792.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	197,738.7	197,738.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,079,531.0	4,079,531.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-955.1	-955.1
5	Тайлант үеийн үр дүн	765,342.5	765,342.5
6	2024 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	4,843,918.5	4,843,918.5
7	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,843,918.5	4,843,918.5
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,843,918.5	4,843,918.5
9	Тайлант үеийн үр дүн	534,624.5	534,624.5
10	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,378,543.0	5,378,543.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,569,682.7	2,532,823.3
2	ТАТВАРЫН ОРЛОГО	1,152,545.9	1,330,171.7
3	Орлогын албан татвар	1,092,145.4	1,220,713.6
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(20,272.3)	(19,761.8)

5	Хөрөнгийн албан татвар	40,111.8	41,274.5
6	Бусад татвар, төлбөр, хураамж	20,288.7	68,183.5
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,552.0	3,274.4
8	Газрын төлбөр	14,670.6	7,152.4
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	66.2	57,756.7
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	163,488.1	1,202,651.6
11	Нийтлэг татварын бус орлого	163,488.1	359,221.6
12	Тусламжийн орлого	-	217,469.8
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	625,960.3
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,253,648.7	-
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,447,362.3	1,403,223.2
16	УРСГАЛ ЗАРДАЛ	1,447,362.3	1,403,223.2
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,379,782.9	1,362,262.2
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	691,006.2	771,757.0
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,173.9	94,861.4
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	263,545.2	245,717.1
21	Хангамж, бараа материалын зардал	62,183.9	51,819.5
22	Нормативд зардал	1,595.0	102.0
23	Эд хогшил, урсгал засварын зардал	58,720.2	137,034.4
24	Томилолт, зочны зардал	24,440.0	22,406.0
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,623.7	5,037.9
26	Бараа үйлчилгээний бусад зардал	140,494.8	33,526.9
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,579.5	40,961.0
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,122,320.3	1,129,600.2
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	556,214.8	1,039,061.3
30	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	556,214.8	1,039,061.3
31	Дотоод эх үүсвэрээр	556,214.8	1,039,061.3
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(556,214.8)	(1,039,061.3)
33	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	566,105.5	90,538.9
34	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	702,250.0	1,268,355.5
35	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,268,355.5	1,358,894.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,461,773.3	2,516,847.7	(944,925.6)	72.7

11	Татварын орлого	1,218,317.7	1,330,171.7	111,854.0	109.2
110	Орлогын албан татвар	1,115,569.2	1,220,713.6	105,144.4	109.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,135,331.0	1,240,475.4	105,144.4	109.3
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	1,051,625.0	1,143,169.7	91,544.7	108.7
110002	Үйл ажиллагааны орлого	4,060.0	4,810.2	750.2	118.5
110003	Хөрөнгийн орлого	52,220.1	62,189.5	9,969.4	119.1
110004	Хөрөнгө борлуулсны орлого	-	3,790.0	3,790.0	-
110008	Шууд бус орлого	27,425.9	26,515.9	(910.0)	96.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(19,761.8)	(19,761.8)	0.0	100.0
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(19,761.8)	(19,761.8)	0.0	100.0
113	Хөрөнгийн албан татвар	38,058.1	41,274.5	3,216.4	108.5
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	4,966.2	7,080.4	2,114.2	142.6
113002	Бууны албан татвар	1,680.0	2,280.0	600.0	135.7
113004	Малд ногдуулах албан татвар	31,411.9	31,914.1	502.2	101.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	64,690.4	68,183.5	3,493.1	105.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,234.4	3,274.4	2,040.0	265.3
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,234.4	1,234.4	-	100.0
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	-	2,040.0	2,040.0	-
1181	Газрын төлбөр	6,500.0	7,152.4	652.4	110.0
118101	Газрын төлбөр	6,500.0	7,152.4	652.4	110.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	56,956.0	57,756.7	800.7	101.4
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	55,456.0	56,206.2	750.2	101.4
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1,500.0	1,550.5	50.5	103.4
12	Татварын бус орлого	1,074,769.9	1,186,676.0	111,906.1	110.4
120	Нийтлэг татварын бус орлого	1,074,769.9	1,186,676.0	111,906.1	110.4
120003	Торгуулийн орлого	2,938.9	21,040.5	18,101.6	715.9
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	199,500.0	329,274.7	129,774.7	165.0

120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	30,000.0	137.7	(29,862.3)	0.5
120009	Бусад орлого	-	215.0	215.0	-
122	Тусламжийн орлого	210,047.9	210,047.9	-	100.0
122003	Аймаг нийслэлээс авсан татаас	210,047.9	210,047.9	-	100.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	632,283.1	625,960.3	(6,322.8)	99.0
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	632,283.1	625,960.3	(6,322.8)	99.0
	Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих	1,168,685.70		(1,168,685.7)	-
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,461,773.30	2,431,742.03	1,030,031.3	70.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,631,392.60	1,401,096.07	230,296.5	85.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,578,478.40	1,360,135.07	218,343.3	86.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	839,836.20	771,756.98	68,079.2	91.9
210101	Үндсэн цалин	384,146.50	381,108.56	3,037.9	99.2
210102	Нэмэгдэл	312,719.30	285,059.61	27,659.7	91.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,320.00	21,685.00	12,635.0	63.2
210104	Урамшуулал	35,230.80	26,850.56	8,380.2	76.2
210105	Гэрээт ажлын хөлс	73,419.60	57,053.25	16,366.4	77.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,305.10	94,861.35	10,443.7	90.1
210201	Тэтгэврийн даатгал	70,710.70	65,265.05	5,445.6	92.3
210202	Тэтгэмжийн даатгал	8,648.70	7,443.68	1,205.0	86.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,324.30	3,721.84	602.5	86.1
210204	Ажилгүйдлийн даатгал	4,324.30	3,652.65	671.6	84.5
210205	Эрүүл мэндийн даатгал	17,297.10	14,778.13	2,519.0	85.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	256,684.10	245,717.07	10,967.0	95.7
210301	Гэрэл, цахилгаан	45,234.20	34,683.50	10,550.7	76.7
210302	Түлш, халаалт	204,008.10	203,849.83	158.3	99.9
210303	Цэвэр, бохир ус	7,441.80	7,183.74	258.1	96.5
2104	Хангамж, бараа материалын зардал	67,052.20	51,078.06	15,974.1	76.2
210401	Бичиг хэрэг	6,150.00	3,508.95	2,641.1	57.1

210402	Тээвэр, шатахуун	53,102.20	43,133.91	9,968.3	81.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,000.00	1,603.50	2,396.5	40.1
210404	Ном, хэвлэл	800.00	90.00	710.0	11.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000.00	2,741.70	258.3	91.4
2105	Нормативд зардал	510.00	102.00	408.0	20.0
210502	Хоол, хүнс	510.00	102.00	408.0	20.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	146,069.10	144,449.70	1,619.4	98.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000.00	8,410.30	1,589.7	84.1
210604	Урсгал засвар	136,069.10	136,039.40	29.7	100.0
2107	Томилолт, зочны зардал	32,376.00	22,406.00	9,970.0	69.2
210702	Дотоод албан томилолт	32,376.00	22,406.00	9,970.0	69.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,673.90	5,037.91	5,636.0	47.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,508.90	2,983.00	3,525.9	45.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200.00	403.20	796.8	33.6
210803	Даатгалын үйлчилгээ	300.00	64.35	235.7	21.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	825.00	202.36	622.6	24.5
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150.00	121.00	29.0	80.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,690.00	1,264.00	426.0	74.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	119,971.80	24,726.00	95,245.8	20.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	115,211.80	23,418.10	91,793.7	20.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,760.00	1,307.90	3,452.1	27.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,914.20	40,961.01	11,953.2	77.4
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,733.20	-	8,733.2	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	41,681.00	39,681.01	2,000.0	95.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500.00	1,280.00	1,220.0	51.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,684,380.70	1,030,645.96	653,734.7	61.2
223001	Бусад хөрөнгө	1,684,380.70	1,030,645.96	653,734.7	61.2

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	146,000.00	-	146,000.0	-
230001	Эргэж төлөгдөх зээл	146,000.00	-	146,000.0	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,268,355.48	(1,268,355.5)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,358,894.38	(1,358,894.4)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны нэр, төрөл	Тайлант он
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,421.9
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,721.9
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,700.0
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,206.9
УРСГАЛ ЗАРДАЛ	7,206.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,206.9
Хангамж, бараа материалын зардал	741.4
Тээвэр, шатахуун	621.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	120.0
Бараа үйлчилгээний бусад зардал	6,465.4
Төвлөрүүлэх шилжүүлэг	215.0

3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Алтай сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг түүвэрт хамруулсан

3.1 Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 1,066.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 2 алдааг залруулж, 8.7 сая төгрөгийн зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 3.5 сая төгрөгийн 3 зөвлөмж, 1 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.

3.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 859.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 7 алдааг залруулж, 2.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 13.6 сая

төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж, 18.2 сая төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

3.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар залруулга хийгээгүй болно.

Аудитаар нийт 6.9 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын төвшнөөс бага бөгөөд харьяа байгууллагуудын материаллаг зөрчил 47.0 сая төгрөг байгаа тул шинж чанарыг харгалзан үзэж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 6.9 сая төгрөгийн 2 зөрчил илрүүлснээс, 6.9 сая төгрөгийн 1 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлсэн.

3.4 Албан шаардлага

1. Төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 47.0 сая төгрөгийн төгрөгийн 8 зөрчил илэрч 2.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 26.9 сая төгрөгийн 2 зөрчил арилгах албан шаардлага, 17.2 сая төгрөгийн 1 зөвлөмж, 1 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах

3.5 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой

Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгө арга хэмжээний зардлаас дэмжлэг хүндэтгэл үзүүлэхэд 3.1 сая төгрөгийг, ахмадын баярт 2.2 сая төгрөгийг, Улс тунхагласны баярын тэмцээн уралдаанд 1.5 сая төгрөгийн тус тус зарцуулсан Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжид нийцүүлэн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг зориулалтын дагуу зарцуулах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Алтай сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Алтай сумын ЗДТГ	2	1,066,325.50	1	897,661.60	1	168,663.90	2	1,066,325.50	-	-	-	-
Алтай сумын ОНХС	4	858,339.92	1	139,308.60	3	719,031.32	4	858,339.92	-	-	-	-
Алтай сумын ХХС	3	1,611.50			3	1,611.50	3	1,611.50	-	-	-	-
Дүн	9	1,926,276.92	2	1,036,970.20	7	889,306.72	9	1,926,276.92	-	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Бүгд	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс	Түүвэрт	Нийт зөрчил		Үүнээс										
									Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Алтай сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	1		1	-	-	-	2	6,904.0	-	-	1		1	6,904.0		-	-	-	
Алтай сумын ЗДТГ	1	1		-	-	-	5	12,276.40	-	-	1	8,713.50	3	3,562.9	1		-	-	-
Алтай сумын ИТХ	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Алтай сумын сумын ОНХС	1					1	1	13,630.50	-	-	-	-	1	13,630.5	-	-	-	-	-
Алтай сумын сумын БХНСС	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Алтай сумын сумын ХХС	1	-	-	-	-	1	2	2,941.2	1	2,941.2	1	18200.0	-	-	-	-	-	-	-
Дүн	5	2		-	-	3	10	53,952.10	1	2,941.20	3	26,913.50	5	24,097.40	1				-

